

# БНЧУ-ЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦОО НЬ ТАНАЙ ЭХ ОРНЫ ТОГТОЛЦООНООС ӨӨР БАЙЖ БОЛНО!

**Хүн бүр дараах газруудад бүртгэлтэй байх ёстой:**

- өрхийн эмчид / хүүхдийн эмчид,
- шүдний эмчид,
- эмэгтэйчүүдийн эмчид.

**Эдгээр эмч нарт хүн бүр тогтмол урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагддаг бөгөөд энэ нь үнэ төлбөргүй байдаг (эрүүл мэндийн даатгалаар төлдөг). Урьдчилан сэргийлэх нь болзошгүй хурц асуудлуудаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Эцэг эхчүүд хүүхэдтэйгээ хүүхдийн эмчид тогтмол очиж үзэх үүрэгтэй!**

**Шаардлагатай тохиолдолд тусгай мэргэжлийн эмчид хандах** (жиш. зүрх судасны эмч, эндокринолого – бамбай булчирхай болон гормоны асуулалд, мэдрэлийн эмч, чихрийн шижин эмч г.м.) **бол ерөнхий эмч (хүүхдийн эмч) танд хүсэлт/зөвлөмж бичнэ.**

- Хэрэв та тусгай мэргэжлийн эмчийн аль нэгний үзлэгт хамрагдсан бол санал болгож буй давтан үзлэгт хамрагдах ёстой.

**!!! Эмч дээр цаг авсан бол цагтаа ирэх ёстой гэдгийг битгий мартаарай!!! Хэрэв та ирж чадахгүй бол урьдчилан уучлалт гуйх/цуцалж, өөр өдөр, цаг тохирох хэрэгтэй.**

## ГЭНЭТИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ТҮРГЭН ТУСЛАМЖ	ЭМНЭЛГИЙН АВРАХ АЛБА – 112
<p>Гэнэтийн, амь насанд аюул учраагүй эрүүл мэндийн асуудалд!</p> <ul style="list-style-type: none"><li>- Ихэвчлэн эмнэлгүүдэд байх ба гэмтлийн эмнэлгийн түргэний хүлээн авахаас олж болно.</li></ul> <p><i>Түргэн тусламжийн хувьд зохицуулалтын хураамж төлдөг.</i></p> <p>Түргэн тусламж нь эмч нарын ажлын бус цагаар (жишээ нь орой эсвэл амралтын өдрүүдэд) ажилладаг.</p>	<p>Гэнэтийн, амь насанд аюул учирсан эрүүл мэндийн ноцтой асуудалд!</p> <ul style="list-style-type: none"><li>- ноцтой гэмтэл, ухаан алдах, амьсгалын, хордлого, харшил эсвэл эрүүл мэндийн байдал муудах зэрэг нь удаан хугацааны эсвэл байнгын үр дагаварт хүргэж болзошгүй, эсвэл бүр гэнэтийн үхэлд хүргэх тохиолдолд.</li></ul> <p>Энэ нь зогсолтгүй ажилладаг.</p>

**112** - энэ бол Европын бүх нийтийн дугаар (гал команд, аврах алба, цагдаа). Та SIM карт, нэгжгүй байсан ч, сигналгүй газар ч гэсэн энэ дугаар руу залгах боломжтой. Шугаман дээрх операторууд мөн гадаад хэлээр ярьдаг.

**БОДИТ БАЙДЛААС: БНЧУ-д эрүүл мэндийн тусламж үйлчилгээ өндөр түвшинд байгаа ч эмч тань өвчтөн дүүрсэн тохиолдолд бүртгэх шаардлагагүй. Энэ тохиолдолд та эмч хайх эсвэл эмч хайхад тань туслах хэн нэгэнтэй холбоо барих хэрэгтэй.**



Spolufinancováno  
Evropskou unií



MINISTERSTVO VNITRA  
ČESKÉ REPUBLIKY



Projekt "Centrum na podporu integrace cizinců v Ústeckém kraji" reg. č. CZ.12.01.02/00/23\_008/0000008 je financován OP AMIF a MV ČR.